



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/249

Мандалговь

Шүлхийн дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.6, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4.3.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын зөвлөмжийн дагуу 2019 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд Адаацаг, Дэлгэрцогт, Сайнцагаан, Луус, Хулд сумын үхэр болон бог малыг, Дэрэн, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт, Сайхан-Овоо сумын үхрийг малын гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтад хамруулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Хоёр. Шүлхийн дархлаажуулалтад хамруулах малын тоо, вакцины хуваарийг хавсралтаар баталсугай.

Гурав. Дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэхийг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн), захирамжийн хэрэгжилтийг хангуулж, тайлагнаж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГ



Ж.МӨНХЧУЛУУН

438190690



Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 14/49 дүгээр захирамжийн хавсралт

ШҮЛХИЙН ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРУУЛАХ
МАЛЫН ТОО, ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	Сумын нэр	Хамрагдах малын тоо					Шаардагдах вакцин			Үйлчилгээний хөлс
		Үхэр	Хонь	Ямаа	Бүгд		Вакцин мл	Вакцин тун		
1	Адаацаг	8,700	150,000	143,000	301,700		310,400	155,200		45,690,000
2	Дэлгэрцогт	4,800	95,000	93,000	192,800		197,600	98,800		29,160,000
3	Сайнцагаан	7,500	190,000	177,000	374,500		382,000	191,000		56,550,000
4	Луус	5,200	90,000	87,000	182,200		187,400	93,700		27,590,000
5	Хулд	3,700	149,000	137,000	289,700		293,400	146,700		43,640,000
6	Сайхан Овоо	3,400			3,400		6,800	3,400		680,000
7	Баянжаргалан	4,700			4,700		9,400	4,700		940,000
8	Гурвансайхан	4,800			4,800		9,600	4,800		960,000
9	Говь-Угтаал	3,500			3,500		7,000	3,500		700,000
10	Дэрэн	6,700			6,700		13,400	6,700		1,340,000
11	Өндөршил	3,800			3,800		7,600	3,800		760,000
12	Өлзийт	3,600			3,600		7,200	3,600		720,000
13	Цагаандэлгэр	3,300			3,300		6,600	3,300		660,000
14	МАЗМАЛба	3,300			3,300		6,600	3,300		660,000
	Аймгийн дүн	67,000	674,000	637,000	1,378,000		1,445,000	722,500		210,050,000